

## **ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

(2015 оны 2 дугаар улирлын байдлаар)

Монголбанкны Хяналт шалгалтын газраас 2015 оны 2 дугаар улиралд хийж гүйцэтгэсэн ажлын ерөнхий мэдээллийг танилцуулж байна.

- Тайлант улиралд 4 банкинд газар дээрх иж бүрэн шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд шалгалтаар холбогдох журмын дагуу зээлийн ангиллыг хийж, зээлийн эрсдэлийн санг байгуулдаггүй, хуримтлуулж тооцсон хүүг тэнцлийн гадуур гарган бүртгэдэггүй, зээлийн мэдээллийн санд мэдээлэл оруулаагүй, буруу зөрүүтэй мэдээлэл оруулсан зарим банкуудын хувьд Монголбанкнаас өмнөх шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийг зөрчсөн зэрэг дутагдлууд илэрлээ. Дээрх банкуудад хийсэн шалгалтын дүнг Хяналт шалгалтын зөвлөлөөр хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулахаар ажиллаж байгаа бөгөөд өмнөх шалгалтаар өгсөн Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалын биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.
- Мөн 3 банкны 40 том зээлийн хувийн хэрэг болон эх үүсвэрийн үлдэгдлүүд түүний эргэн төлөлтөд хэсэгчилсэн шалгалт хийж, шалгалтын дүнг Монголбанкны Хяналт шалгалтын зөвлөлд танилцуулахаар ажиллаж байна. Хэсэгчилсэн шалгалтаар эдгээр банкуудад, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу зээлийн ангиллыг тогтмол хийж, зээлийн эрсдэлийн санг нэмж байгуулах, хуримтлуулж тооцсон зээлийн хүүг тэнцлийн гадуур бүртгэж байхыг үүрэг болгож, холбогдох журмын дагуу Улсын байцаагчийн акт тогтоож, мэдэгдэл хүргүүлэх зэрэг арга хэмжээг авсан болно.
- Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн 2014-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд шинээр батлагдсан “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, “Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-д хараат бус гишүүнийг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар томилж, Монголбанкны зөвшөөрлөөр үүрэгт ажлаас нь чөлөөлөх, системийн нөлөө бүхий банкууд компанийн хэлбэрээс үл хамааран ТУЗ-ийн Хараат бус гишүүн 3 буюу түүнээс дээш байхаар тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Системийн нөлөө бүхий банкуудад ТУЗ-ийн хараат бус гишүүдийг томилуулах арга хэмжээ авч, тушаалын биелэлтэд хяналт тавин ажиллалаа.
- “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”, “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар банкуудад өгсөн үүрэг даалгавар болон холбогдох бусад хууль, тогтоомжуудын хүрээнд банкуудад зайнаас хяналт тавих ажлыг хэрэгжүүлж, банкуудаас сар бүр ирүүлсэн санхүүгийн тайлан мэдээг хянан шалгаж, тохируулгын гүйлгээ хийх шаардлагатай банкны тэнцэлд гүйлгээг хийж, тайлангийн хариуг сар бүр хүргүүлж байна.
- Банкуудын үйл ажиллагаанд зайнаас тавих хяналтын хүрээнд банкуудын санхүү, төлбөрийн чадварын талаарх санхүүгийн ерөнхий дүгнэлт, мэдээллийг боловсруулж, банкуудаас ирүүлсэн тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг, материалыг хууль, журам, зааврын дагуу шалгаж удирдлагад танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулах, банкинд хийх хяналт шалгалтыг хугацаанд нь чанартай, тогтмол, үр ашигтай хэрэгжүүлэх үүднээс гадаадын хөрөнгө оруулалттай банкуудын судалгаа, Банкны тухай хуулийн 38.2 дугаар заалтын биелэлт, салбар нэгжийн өөрчлөлтийн судалгааг боловсруулж удирдлагуудад танилцуулж шаардлагатай арга хэмжээг авсан.

- Тайлант улиралд Монголбанкны Ерөнхийлөгчийн А-151 дүгээр тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-д заасан Банкны зохистой засаглалыг үнэлэх аргачлалын дагуу бүх банкуудаас зохистой засаглалын үнэлгээний тайланг хүлээн авч, хариуцсан хянан шалгагчаар дахин үнэлүүлсэн болно.
- Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх шаардлага болон боломжийн талаар судалгаа хийн, 2015 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн Монголбанкны Ерөнхийлөгчийн А-58 дугаар тушаалаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг болгон шинэчлэн тогтоосон. Тогтоолын хэрэгжилттэй холбоотойгоор одоо үйл ажиллагаа эрхэлж буй банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх хуваарийг баталсан бөгөөд төлөвлөгөөт хугацаанд багтаан банкууд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажиллах төлөвлөгөөг боловсруулан Монголбанкинд ирүүлсэн. Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлснээр банкны системийн эрсдэл даах чадвар сайжрахын зэрэгцээ, банкуудын томоохон төслүүдийг бие даан санхүүжүүлэх боломжийг нэмэгдүүлж, хувь нийлүүлэгчдийн санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх ач холбогдолтой юм.
- Шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн багц материал 2015 оны 2 дугаар сарын 06-нд батлагдсантай холбоотойгоор банкуудаас авах тайлангийн загварт холбогдох өөрчлөлтүүдийг оруулан, хяналт шалгалтын програм хангамжийг шинээр суурилуулж, банк хариуцсан хянан шалгагч нарыг сургалтад хамруулж, улмаар 2015 оны 7 сарын 1-ний өдрөөс эхлэн банкуудын тайланг ФИНА системээр авч эхлээд байна.

## **ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР**